

Халонг Бай болон Ханой хот хосолсон аяллын хөтөлбөр 7 шөнө 8 өдөр

Өдөр	Товч Хөтөлбөр	Хоол
Өдөр 1	Улаанбаатар – Ханой нислэг	Оройн хоол
Өдөр 2	Ханой - Ха Лонг Бай	Өглөөний цай, өдөр, оройн хоол
Өдөр 3	Круйз аялал	Өглөөний цай, өдрийн хоол
Өдөр 4	Sun world кабель кар усан паркт аялал	Өглөөний цай, өдрийн хоол
Өдөр 5	Чөлөөт өдөр	Өглөөний цай
Өдөр 6	Ханой Grand world	Өглөөний цай, өдрийн хоол
Өдөр 7	Ханой Чөлөөт өдөр	Өглөөний цай
Өдөр 8	Ханой – Улаанбаатар нислэг	Өглөөний цай

ӨДӨР 1: УЛААНБААТАР- ХАНОЙ

08:00-12:00 Улаанбаатар – ХАНОЙ шууд ниснэ. Нислэг эхлэхээс 3 цагийн өмнө бүртгэл нээгдэх тул ОУ нисэх буудал дээр цугларан аяллын групптэй нэгдэнэ. Вьетнам улсын Ханой хотын нисэх буудалд буун хил гаалиар гаран ачаа тээшээ авна. Хөтөч та бүгдийг угтан авч зочид буудалд хүргэж өгнө. Өрөөгөө хүлээн авсны дараа хэсэг амраад оройн хоолтой.



Дэлхийгээр тойрон аялж хамгийн сайхан дурсамжийг бүтээцгээе!


 AIRPLANE - Аялъя, Хөгжье

ӨДӨР 2: ХАНОЙ - ХАЛОНГ БЭЙ

Өглөөний цайны дараа зочид буудалдаа тухлан, тайван байдлыг мэдэрч, халуун кофе шимэн, усан санд сэлэх эсвэл өрөөндөө тухлах зэргээр цагийг өнгөрүүлнэ. Товлосон цагт Ханой хотоос хөдөлж, Улаан голын хөндий дагуух ногоон төгөл, үзэсгэлэнт байгальтай Халонг хот руу аяллаа эхлүүлнэ. Халонг нь Вьетнам улсын нийслэл Ханойгоос зүүн хойш 170 км зайд орших, аялал жуулчлалын онцгой бүс, ЮНЕСКО-ийн Дэлхийн Соёлын өвд албан ёсоор бүртгэгдсэн, байгалийн үзэсгэлэн төгс цогцолсон, алдартай газар юм.

Сэтгэлийг тань баясгаж, хараа булаам байгалийн санаанд оромгүй тогтоц бүхий, том жижиг 1969 ширхэг хадан цохио бүхий арлуудаас Халонг булан нь бүрддэг. Газар дээрх болон усан доорх био ертөнцийн зохицол болох Халонг булан нь 1500 мв.км талбайг эзэлнэ. Халонг хэмээх үг нь “Луу далайд бууж заларсан газар” гэсэн утгаар орчуулагддаг байна.

Халонгт хүрэлцэн ирмэгц, нутгийн онцлог амтыг мэдрүүлсэн далайн хоолыг орон нутгийн ресторанд зооглоно. Зочид буудалдаа бүртгүүлэн амарч, замын ядаргаа тайлна. Чөлөөт цагаа Бай Чай далайн эрэг дээр өнгөрүүлээрэй.



ӨДӨР 3: ХАЛОНГ БЭЙ КРУЙЗ АЯЛАЛ

Өглөөний цайгаа тухтай уугаад дараа нь Туан Чау боомт руу очин 5–6 цаг үргэлжлэх завин аялалдаа гарна. Завин дээр далайн хоол идэж, өвөрмөц хэлбэртэй арал, хаднуудыг үзнэ. Эхлээд “Гайхамшигт агуй”-г үзэж, сонирхолтой хэлбэртэй чулуу, тогтоцтой танилцана. Дараа нь Титоп аралд очиж, цагаан элстэй эрэг дээр амарч, оргилд нь гарч Халонг булангийн гайхалтай байгалийг харна. Луон агуйд очиж, завиар эсвэл бамбу завиар сэлж, үзэсгэлэнт нуур, тайван байгальтай танилцана. Буцаж явахдаа завин дээр нар жаргахыг харангаа цай ууж, амттан идэн, хөгжим сонсон, хамт аялж буй хүмүүстэй хөгжилтэй мөчүүдийг хуваалцана. Орой зочид буудалдаа буцаж ирж, адал явдалтай, сайхан өдрийг инээмсэглэлээр үднэ.

Дэлхийгээр тойрон аялж хамгийн сайхан дурсамжийг бүтээцгээе!



ӨДӨР 4: SUN WORLD КАБЛЬ КАР УСАН ПАРКТАЙ АЯЛАЛ

Өглөөний цайгаа тухтай зооглоод, адал явдал, инээд хөөрөөр дүүрэн өдрийг өнгөрүүлэхээр Sun World Halong цогцолбор руу явна. Cable car буюу цахилгаан шатаар тэнгэрт тулсан уулс, Халонг булангийн сүр жавхлант байгалийг дээрээс нь тольдоно. Энэхүү зураг шиг үзэмж таны зүрхэнд үүрд хадгалагдана. Турхоон усан парк – Асар өндөр усан гулгуур, далайн долгион үүсгэгч усан сан гэх мэт олон тоглоом нь хүүхэд, хөгшид хүн бүрт тохиромжтой тул өдөржин тоглож өнгөрүүлнэ.



Дэлхийгээр тойрон аялж хамгийн сайхан дурсамжийг бүтээцгээе!

ӨДӨР 5: ЧӨЛӨӨТ ӨДӨР

Энэ өдрийг та амрах, зугаалах, дэлгүүр хэсэх эсвэл зүгээр л өөртөө цаг зориулах гэх мэт хүссэнээрээ өнгөрүүлэх боломжтой.

ӨДӨР 6: ХА ЛОНГ БАЙ - ХАНОЙ GRAND WORLD

Өглөөний цайгаа зооглоод Ханой хот руу буцна. Ханойд ирээд өдрийн хоолтой. Дараа нь хэсэг амраал Grand World Hanoi цогцолбор руу хөдөлнө. Grand World Hanoi-д зочилж, чөлөөт цагийг европ хэв маягтай барилгууд, хязгааргүй зугаа цэнгэлийн ертөнцөөр аялна. Шинэ бөгөөд сонирхол татам энэ газарт та зураг дарж, зугаалж, амрах гээд хүссэнээрээ цагийг өнгөрүүлэх боломжтой.



Дэлхийгээр тойрон аялж хамгийн сайхан дурсамжийг бүтээцгээе!

 AIRPLANE - Аялъя, Хөгжье

ӨДӨР 7: ХАНОЙ ЧӨЛӨӨТ ӨДӨР

Энэ өдрийг та өөрийнхөөрөө, тайван бөгөөд дурсамжтай өнгөрүүлэх боломжтой. Өглөөний цайны дараа та хүссэн газраа очиж, сонирхсон зүйлсээ хийгээрэй.

- Ханой хотын уламжлалт зах, гар урлалын дэлгүүрүүдээр зочлох
- Вьетнамын нэрийн хуудас болсон гудамжны амтат хоолнуудаас амтлах
- Хотын түүхэн дурсгалт газруудаар зугаалах
- Уламжлалт вьетнам кафе-д тухлан, Ханойн уур амьсгалыг мэдэрч амрах

ӨДӨР 8: ХАНОЙ - УЛААНБААТАР

Өглөөний цайгаа уугаад зочид буудлаа хүлээлгэн өгч ачаа тээшээ аван нисэх буудал ороод **13:00-19:00** шууд нислэгээр Монгол буцаж бидний аялал өндөрлөнө.

Аяллын хөтөлбөр	Том хүн:	Хүүхэд 2-11 нас ор эзлэхгүй	Нярай буюу 0- 2 нас	Аяллын өдөр
2 талын дан тийз –	2,390,000₮	2,390,000₮	390,000₮	6/18-25 6/25-7/02 7/02-09 7/09-16 7/16-23 7/23-30 7/30-8/06 8/06-8/13 8/13-8/20
Хөтөлбөртэй аялал 4 одтой буудалтай	3,590,000₮	3,090,000₮	390,000₮	

Жич зөвхөн дараах 2 өдрийн нислэгийн цаг өөрчлөгдөнө. 7/23 ubn-han 14:30-18:30 han-ubn 19:30-01:30
8/13 ubn-han 02:30-06:30 han-ubn 07:30-13:30

АЯЛЛЫН ҮНЭД БАГТСАН ЗҮЙЛС:

- + Улаанбаатар -Ханой-Улаанбаатар нислэгийн тийз
- + Зочид буудлын стандарт twin өрөө /1өрөөнд 2том хүн орно, хүүхэд оргүй/
- + Зочид буудлын буффет өглөөний цай
- + Хөтөлбөр тусгагдсан өдөр болон оройн хоол
- + Хөтөлбөрт тусгагдсан үзвэр үйлчилгээний тасалбар
- + Гадаадад зорчигчийн иж бүрэн даатгал
- + Дата биет сим карт

АЯЛЛЫН ҮНЭД БАГТААГҮЙ ЗҮЙЛС:

- + Хувийн хэрэглээний зардал
- + Нэмэлт үзвэр үйлчилгээний зардал
- + Чөлөөт өдрийн хөтчийн зардал
- + Хөтөлбөрт тусгагдаагүй өдөр болон оройн хоол
- + Нутгийн хөтөч болон жолоочийн гарын мөнгө

Дэлхийгээр тойрон аялж хамгийн сайхан дурсамжийг бүтээцгээе!

 AIRPLANE - Аялья, Хөгжье

HALONG HOTEL NOVOTEL HA LONG BAY 4* OR SIMILAR



Дэлхийгээр тойрон аялж хамгийн сайхан дурсамжийг бүтээцгээе!

 AIRPLANE - Аялъя, Хөгжье

ХАНОЙ ЗОЧИД БУУДАЛ : CAPTIAL GARDEN HOTEL 4* OR SIMILAR



Уг буудалтай ойрхон үзвэр үйлчилгээ, рестораны байршил

- US Embassy - 12 min walk - 1.1 km
- Lotte Center Hanoi - 3 min drive - 2.2 km
- Ho Chi Minh Mausoleum - 5 min drive - 4.8 km
- Hoan Kiem Lake - 7 min drive - 6.4 km
- Hanoi Old Town Night Market - 7 min drive - 6.3 km
- Hanoi (HAN-Noi Bai Intl.) - 36 min drive
- Hanoi Railway Station - 15 min drive
- Ga Thuong Tin Station - 17 min drive
- Hanoi Giap Bat Station - 19 min drive
- Airport shuttle (surcharge)
- Legend Beer - 6 min walk
- Charm Coffee - 3 min walk
- Joie - Góc sân và khoảng trời - 2 min walk
- Hotwheels Cafe Lounge - 3 min walk
- Nghêu sò ốc - 1 min walk

Дэлхийгээр тойрон аялж хамгийн сайхан дурсамжийг бүтээцгээе!

 AIRPLANE - Аялъя, Хөгжье